

МӨНГӨНИЙ ТОЙМ

2016 оны 9 дүгээр сар

ХУРААНГУЙ:

- Тайлант сард мөнгөний нийлүүлэлт (M2) өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өсч 11.5 их наяд төгрөгт хүрчээ.
- Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өсч 8109.3 тэрбум төгрөгт хүрснээс 69.9 хувийг төгрөгийн, 30.1 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.
- Банкнаас бусад санхүүгийн байгууллагын зээлийг тооцохдоо тухайн байгууллагад банк, санхүүгийн байгууллагаас олгосон санхүүжилтийг хасч тооцдог байсныг олон улсын стандартад нийцүүлэн өөрчилж, тайлант сараас эхлэн хасахгүйгээр зарладаг боллоо.
- Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсч 19.2 их наяд төгрөгт хүрчээ. Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн 40.3 хувь нь иргэд, 39.2 хувь нь хувийн хэвшил, 20.5 хувь нь улсын байгууллагад олгосон зээл байна.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


| | | 2013 | 2014 | 2015 | 2016 | | | |
|--|-------------------|----------|----------|----------|----------|----------|----------|---------|
| | | 12-р сар | 12-р сар | 12-р сар | 3-р сар | 6-р сар | 8-р сар | 9-р сар |
| Улаанбаатар хотын инфляци | <i>сарын</i> | 1.7 | 0.6 | -0.2 | 0.3 | -0.5 | -0.6 | -0.9 |
| | <i>оны эхнээс</i> | 11.2 | 10.7 | 1.1 | 1.5 | 2.7 | 1.0 | 0.1 |
| | <i>жилийн</i> | 11.2 | 10.7 | 1.1 | 1.1 | 1.2 | -0.6 | -0.7 |
| Суурь инфляци | <i>сарын</i> | 1.3 | 0.4 | -0.1 | -0.4 | -0.1 | 0.3 | 0.3 |
| | <i>оны эхнээс</i> | 12.1 | 12.6 | 4.8 | -1.1 | -1.2 | -1.0 | -1.0 |
| | <i>жилийн</i> | 12.1 | 12.6 | 4.8 | 3.1 | 3.0 | 0.8 | 0.8 |
| Улсын инфляци | <i>сарын</i> | 0.7 | 0.8 | -0.2 | 0.5 | -0.3 | -1.0 | -0.6 |
| | <i>оны эхнээс</i> | 11.9 | 11.0 | 1.9 | 1.7 | 2.9 | 1.2 | 0.6 |
| | <i>жилийн</i> | 11.9 | 11.0 | 1.9 | 1.7 | 1.6 | -0.2 | -0.1 |
| Нөөц мөнгө, тэрбум ₮ | 3,335.5 | 3,426.5 | 2,459.6 | 2,360.7 | 3,526.1 | 3,257.5 | 3,096.4 | |
| <i>сарын өөрчлөлт, хувиар</i> | 18.1 | 27.9 | 17.9 | 2.3 | 10.0 | 0.8 | -4.9 | |
| <i>жилийн өөрчлөлт, хувиар</i> | 54.0 | 2.7 | -28.2 | -4.4 | 49.9 | 15.3 | 28.5 | |
| M2 мөнгө, тэрбум ₮ | 9,454.9 | 10,635.8 | 10,050.2 | 10,113.7 | 11,188.2 | 11,265.2 | 11,450.1 | |
| <i>сарын өөрчлөлт, хувиар</i> | 3.9 | 7.1 | 2.5 | 1.0 | 5.0 | -0.4 | 1.6 | |
| <i>жилийн өөрчлөлт, хувиар</i> | 24.2 | 12.5 | -5.5 | 2.1 | 11.4 | 13.1 | 15.3 | |
| Бусад хадгаламж, тэрбум ₮ | 7,361.7 | 8,819.1 | 8,364.8 | 8,530.0 | 9,206.8 | 9,359.0 | 9,519.7 | |
| <i>сарын өөрчлөлт, хувиар</i> | 1.2 | 7.0 | 1.4 | 0.4 | 3.3 | -0.2 | 1.7 | |
| <i>жилийн өөрчлөлт, хувиар</i> | 27.4 | 19.8 | -5.2 | 0.9 | 9.9 | 12.9 | 14.4 | |
| Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮ | 841.1 | 809.7 | 706.7 | 658.6 | 839.2 | 817.2 | 795.8 | |
| <i>сарын өөрчлөлт, хувиар</i> | 4.6 | 5.3 | -0.5 | 0.5 | 6.5 | -0.1 | -2.6 | |
| <i>жилийн өөрчлөлт, хувиар</i> | 1.5 | -3.7 | -12.7 | -6.3 | 11.0 | 5.5 | 3.6 | |
| Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮ | 12,570.6 | 16,566.6 | 17,915.5 | 18,414.3 | 18,411.2 | 19,129.7 | 19,240.1 | |
| <i>сарын өөрчлөлт, хувиар</i> | | | 0.5 | 1.5 | 1.7 | 2.8 | 0.6 | |
| <i>жилийн өөрчлөлт, хувиар</i> | -99.8 | 31.8 | 8.1 | 8.1 | 7.3 | 8.8 | 8.1 | |
| Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮ | 10,771.2 | 12,503.5 | 11,706.6 | 11,840.1 | 12,031.3 | 12,442.0 | 12,490.9 | |
| <i>сарын өөрчлөлт, хувиар</i> | -99.9 | -1.2 | -1.6 | 1.7 | 5.1 | 2.8 | 0.4 | |
| <i>жилийн өөрчлөлт, хувиар</i> | -99.8 | 16.1 | -6.4 | -3.5 | 0.6 | 5.0 | 4.6 | |
| Хадгаламжийн байгууллагуудын чанаргүй зээл, тэрбум ₮ | 566.0 | 625.7 | 869.8 | 967.9 | 1,035.6 | 1,126.1 | 1,119.3 | |
| <i>сарын өөрчлөлт, хувиар</i> | -99.9 | 0.9 | 0.5 | 6.2 | -2.6 | 9.3 | -0.6 | |
| <i>жилийн өөрчлөлт, хувиар</i> | -99.8 | 10.6 | 39.0 | 37.7 | 33.8 | 30.1 | 31.3 | |
| Хадгаламжийн ЖДХ | 12.1 | 12.5 | 13.3 | 13.3 | 13.3 | 13.1 | 13.2 | |
| Зээлийн ЖДХ** | 17.4 | 19.5 | 19.1 | 19.7 | 19.1 | 19.4 | 20.1 | |
| Ипотекийн зээлийн хүү | 9.90 | 9.90 | 8.82 | 8.81 | 7.74 | 8.41 | 8.68 | |
| ТБҮЦ-ны ЖДХ | 10.5 | 12.1 | 13.0 | 12.0 | 10.5 | 12.3 | 16.0 | |
| Бодлогын хүү | 10.50 | 12.00 | 13.00 | 12.00 | 10.50 | 15.00 | 15.00 | |
| БХЗ-ын ЖДХ | 8.91 | 12.20 | 11.84 | 12.55 | 11.33 | 13.69 | 15.87 | |

* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

** Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт


Зураг 1. Мөнгөний үзүүлэлтүүдийн жилийн өсөлт



Тайлант сард мөнгөний нийлүүлэлт (M2) өмнөх сараас 1.6 хувь, оны эхнээс 13.9 хувь, өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өсч 11.5 их наяд төгрөгт хүрчээ. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 13.0 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт, 2.3 нэгж хувийг M1 мөнгөний өсөлт бүрдүүлж байна.

M1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.6 хувь буюу 316.8 тэрбум төгрөгөөр өсч, мөнгөний нийлүүлэлтийн 16.9 хувь буюу 1930.5 тэрбум төгрөгийг эзэлж байна. M1 мөнгийг бүрдүүлж буй хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.9 хувь буюу 158.3 тэрбум төгрөгөөр, төгрөгийн харилцах 13.1 хувь буюу 158.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Зураг 2. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа



Бусад харилцах, хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.4 хувь буюу 1198.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтийн 83.1 хувь буюу 9519.7 тэрбум төгрөгийг эзэлж байна. Төгрөгийн хадгаламж бусад харилцах, хадгаламжийн 59.5 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9.4 хувь буюу 485.2 тэрбум төгрөгөөр өсчээ.


Гадаад валютын харилцах, хадгаламжийн өсөлтийн хувь харьцангуй өндөр байна. Гадаад валютын харилцах өмнөх оны мөн үеэс 35.3 хувь буюу 367.8 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 16.5 хувь буюу 345.8 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа (тэрбум ₮)



Хадгаламж, харилцах

Зураг 4. Хадгаламж, түүний жилийн өсөлт



Нийт хадгаламж өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй ч өмнөх оны мөн үеэс 11.4 хувь буюу 831.0 тэрбум төгрөгөөр өсч 8109.3 тэрбум төгрөгт хүрэв.


Нийт хадгаламжийн 69.9 хувийг төгрөгийн, 30.1 хувийг гадаад валютын хадгаламж эзэлж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн хувийн жин өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан байна.

Иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 1.4 хувь буюу 70.3 тэрбум төгрөгөөр өсч 4986.6 тэрбум төгрөгт хүрчээ. Байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 3.6 хувь буюу 23.9 тэрбум төгрөгөөр өсч 681.4 тэрбум төгрөг болов.

Иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас 2.0 хувь буюу 35.3 тэрбум төгрөгөөр өсчээ. Байгууллагуудын гадаад валютын хадгаламж өмнөх сараас 4.2 хувь буюу 30.4 тэрбум төгрөгөөр өсчээ.


Төгрөгийн харилцах өмнөх сараас 3.6 хувиар буурч 1364.8 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын харилцах өмнөх сараас 13.2 хувиар өсч 1410.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 5. Харилцах, түүний жилийн өөрчлөлт



Гадаад, дотоод цэвэр актив

Зураг 6. Гадаад, дотоод цэвэр актив




Тухайн сард Монгол улсын хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 5.7 хувь, оны эхнээс 6.1 хувь, өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар буурч -4144.5 тэрбум төгрөг болов.

Дотоод цэвэр актив өмнөх сараас 0.5 хувиар буурч 7305.7 тэрбум төгрөг болжээ.

Нөөц мөнгө

Зураг 7. Нөөц мөнгө




Нөөц мөнгө өмнөх сараас 4.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 28.5 хувиар өсч 3096.4 тэрбум төгрөг болжээ. Нөөц мөнгөний өсөлтөд банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулбал 40 хувь буюу 657.3 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 38.9 хувь буюу 158.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин банкуудын касс өмнөх оны мөн үеэс 36.2 хувь буюу 129.5 тэрбум төгрөгөөр буурчээ. Тайлант сарын эцсийн байдлаар банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж нөөц мөнгөний 74.4 хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 18.3 хувь, банкуудын касс 7.4 хувийг тус тус эзэлж байна.

Зээл

Банкнаас бусад санхүүгийн байгууллагын зээлийг тооцохдоо тухайн байгууллагад банк, санхүүгийн байгууллагаас олгосон санхүүжилтийг хасч тооцдог байсныг олон улсын стандартад нийцүүлэн өөрчилж, тайлант сараас эхлэн хасахгүйгээр зарладаг боллоо. Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сараас 0.9 нэгж хувиар өсч жилийн 8.1 хувийн өсөлттэй байна. Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн үлдэгдэл 19.2 их наяд төгрөг байгаагийн 40.3 хувь нь иргэд, 39.2 хувь нь хувийн хэвшил, 20.5 хувь нь улсын байгууллагад олгосон зээл байна.

Зураг 8. Зээлийн үлдэгдэл болон жилийн өөрчлөлт




Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн 64.9 хувь буюу 12.5 их наяд төгрөгийг хадгаламжийн байгууллагуудын, 35.1 хувь буюу 6.7 их наяд төгрөгийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл бүрдүүлж байна. Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сараас 4.5 хувь буюу 828.9 тэрбум төгрөгөөр өсчээ.

Санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон зээл өмнөх сараас 3.2 хувь буюу 237.2 тэрбум төгрөгөөр өсч 7744.3 тэрбум төгрөгт хүрчээ. Хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 4.2 хувь буюу 303.5 тэрбум төгрөгөөр өсч 7544.0 тэрбум төгрөг болжээ.

Нийт санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн 83.9 хувийг хэвийн зээл, 10.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.8 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Нийт зээлд


Зураг 9. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувь, чанаргүй зээлийнх 1.0 нэгж хувиар өсчээ. Харин хадгаламжийн байгууллагуудын зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 9.0 хувь байгаа бөгөөд татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.5 хувийг эзэлж байна.


Банкуудаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон картын зээлийн үлдэгдэл нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 1.8 хувийг бүрдүүлж байна. Картын зээл 9 дүгээр сарын байдлаар 223.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.3 хувь буюу 5.2 тэрбум төгрөгөөр буурчээ. Иргэдэд олгосон картын зээл өмнөх сараас 5.3 хувиар буюу 11.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Картын зээлийн 88.1 хувь нь хэвийн, 5.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 6.5 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 90.9 хувь нь төгрөгөөр, 9.1 хувь нь гадаад валютаар олгогдсон байна.

Зураг 10. Картын зээл



Мөнгөний зах

Зураг 11. Банк хоорондын арилжааны хэмжээ, хүү




2016 оны 9 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 921.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Үүний 565.5 тэрбум төгрөгийг овернайт зээл, 223.2 тэрбум төгрөгийг репо арилжаа, 95.5 тэрбум төгрөгийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 37.0 тэрбум төгрөгийг банк хоорондын хадгаламж бүрдүүлжээ.

Банкууд 2016 оны 8 сарын 31-ний өдрөөс 9 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 1066.7 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцийг хангах зорилгоор дунджаар 1210.6 тэрбум төгрөг Төв банк дахь харилцах дансанд төвлөрүүлсэн байна.

Хүү

Зураг 12. Зээл, хадгаламж, хүү




Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх сараас 0.7 нэгж хувь, өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар өсч 20.1 хувьд хүрчээ. Зээлийн үлдэгдэлд жигнэсэн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсч 18.4 хувьд хүрсэн байна. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 9 дүгээр сарын байдлаар 13.2 хувь байна.

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 3.6 нэгж хувь, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар өсч 15.95 хувьтай байна. Банк хоорондын захын арилжааны жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 2.2 нэгж хувь, өмнөх оны мөн үеэс 2.8 нэгж хувиар нэмэгдэж 15.9 хувьд хүрчээ.

Валютын ханш


Зураг 13. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, 2010.12.31 = 100



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 оны 9 дүгээр сарын эцэст 2287.3 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2243.98 төгрөг байв. Тайлант сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2558.46, хятадын юаньтай харьцах ханш 342.91, японы иентэй харьцах ханш 21.67 төгрөг байлаа.


Инфляци

Зураг 14. Сарын инфляци



Улаанбаатар хотын сарын инфляци 2016 оны 9 дүгээр сарын байдлаар -0.9 хувь байсан бөгөөд үүний -1.0 нэгж хувийг хүнсний барааны үнийн өөрчлөлт, 0.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт бүрдүүлжээ. Тухайн сард хүнсний барааны үнэ 3.6 хувиар буурч, бусад бараа, үйлчилгээний үнэ 0.2 хувиар өссөн байна. Тухайлбал, хүнсний ногооны үнэ 9.2 хувь, махны үнэ 8.4 хувиар буурч, согтууруулах бус ундааны үнэ 6.1 хувь, сахар, чихэрний үнэ 3.8 хувиар өсчээ. Харин тамхины үнэ 1.8 хувь, нүүрсний үнэ 1.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний төлбөр 0.6 хувь, тээврийн

Зураг 15. Жилийн инфляци



үйлчилгээний төлбөр 0.5 хувиар өсч, гэр ахуйн тавилганы үнэ 1.0 хувиар буурсан байна.

2016 оны 9 сарын байдлаар Улаанбаатар хотын жилийн инфляци -0.7 хувь байна. Үүний -1.0 нэгж хувийг хүнсний бараа, 0.3 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өөрчлөлт бүрдүүлж байна. Хүнсний барааны жилийн инфляци -3.4 хувь гарахад хүнсний ногооны үнэ 14.5 хувь, мах, махан бүтээгдэхүүний үнэ 7.5 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 6.3 хувиар буурч, сахар, чихрийн үнэ 8.7 хувь, жимсний үнэ 7.6 хувиар өссөн нь нөлөөлжээ. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний хувьд эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 8.1 хувь, согтууруулах ундаа, тамхины үнэ 4.4 хувь, боловсролын бүлгийн үнэ 2.6 хувь, гэр ахуйн тавилга, барааны үнэ 1.4 хувиар өссөн бол орон сууц, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 1.6 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын үйлчилгээний үнэ 1.1 хувиар буурчээ.